

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/46/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.03 № 06/338
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн хүрээнд Архангай аймгийн Чулуут сум, Сүхбаатар аймгийн Наран сумдын эрүүл мэндийн төвийн барилгыг дулааны алдагдалгүй болгон засвар хийж, сэргээгдэх эрчим хүчний халаалтын систем суурилуулах ажлыг хэрэгжүүлэх гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг хугацаандаа дуусган, системийг ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тушаалаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам” болон холбогдох бүтэц, орон тоог батлан Эрчим хүчний яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж рүү шилжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,136,398.31	478,594,215.65
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	193,136,398.31	478,594,215.65
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	193,136,398.31	478,594,215.65
31211	Төрийн сангийн харилцах/төгрөг/	120,575.00	15,989,088.00
31221	Төрийн сангийн харилцах/валют/	193,015,823.31	462,605,127.65
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,412,078,879.37
39400	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	2,412,078,879.37
39403	Дуусаагүй барилга, байгууламж	-	2,412,078,879.37
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	193,136,398.31	2,890,673,095.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	193,136,398.31	2,890,673,095.02
51	Засгийн газрын хувь оролцоо	193,136,398.31	2,890,673,095.02
51200	Хуримтлагдсан үр дүн	193,136,398.31	2,890,673,095.02
51210	Өмнөх үеийн үр дүн	682,052,732.75	193,136,398.31
51220	Тайлант үеийн үр дүн	(488,916,334.44)	2,697,536,696.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	193,136,398.31	2,890,673,095.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	368,129,085.71	3,370,715,786.18
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	366,089,085.71	3,154,582,042.35
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	214,819,066.68
120009	Бусад орлого	2,040,000.00	1,314,677.15
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	856,124,635.19	695,441,824.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,124,635.19	695,441,824.98
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	20,940,909.09	25,800,000.00
210101	Үндсэн цалин	20,940,909.09	25,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,617,613.63	3,225,000.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	2,617,613.63	3,225,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,937,000.00	1,746,682.00
210401	Бичиг хэргийн материал	1,937,000.00	1,746,682.00
2107	Томилолт, зочны зардал	21,306,600.00	87,131,000.00
210701	Гадаад томилолтын зардал	-	34,819,800.00
210702	Дотоод томилолтын зардал	21,306,600.00	52,311,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	807,282,512.47	576,224,465.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,000.00	1,314,677.15
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,000.00	1,314,677.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(487,995,549.48)	2,675,273,961.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	22,262,735.51
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	22,262,735.51
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	920,784.96	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	920,784.96	-
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(488,916,334.44)	2,697,536,696.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	368,129,085.71	958,462,122.81
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	366,089,085.71	957,147,445.66
120009	Бусад орлого	2,040,000.00	1,314,677.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	856,124,635.19	695,267,040.98
21	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,124,635.19	695,267,040.98
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	20,940,909.09	25,800,000.00
210101	Үндсэн цалин	20,940,909.09	25,800,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	2,617,613.63	3,225,000.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	2,617,613.63	3,225,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,937,000.00	1,746,682.00
210401	Бичиг хэрэг	1,937,000.00	1,746,682.00
2107	Томилолт, зочны зардал	21,306,600.00	87,131,000.00
210701	Гадаад албан томилолт	-	34,819,800.00
210702	Дотоод албан томилолт	21,306,600.00	52,311,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	807,282,512.47	576,049,681.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	807,282,512.47	576,049,681.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,000.00	1,314,677.15
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	2,040,000.00	1,314,677.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(487,995,549.48)	263,195,081.83
7	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	22,262,735.51
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	22,262,735.51
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	(920,784.96)	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(920,784.96)	-
8	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(920,784.96)	22,262,735.51
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(488,916,334.44)	285,457,817.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	682,052,732.75	193,136,398.31
100	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,136,398.31	478,594,215.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

		/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	682,052,732.75	682,052,732.75	
Тайлант үеийн үр дүн	(488,916,334.44)	(488,916,334.44)	
2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	193,136,398.31	193,136,398.31	
Тайлант үеийн үр дүн	2,697,536,696.71	2,697,536,696.71	
2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,890,673,095.02	2,890,673,095.02	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

		/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,591,255,000.00	2,891,386,960.52	1,699,868,039.48	63.0

**Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,935,255,000.00	694,127,147.83	1,241,127,852.17	35.9
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,935,255,000.00	694,127,147.83	1,241,127,852.17	35.9
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	25,800,000.00	25,800,000.00	-	100.0
210101	Үндсэн цалин	25,800,000.00	25,800,000.00	-	100.0
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	3,226,000.00	3,225,000.00	1,000.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	2,194,000.00	2,193,000.00	1,000.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	258,000.00	258,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ даатгал	129,000.00	129,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	129,000.00	129,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	516,000.00	516,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,965,000.00	1,746,682.00	218,318.00	88.9
210401	Бичиг хэрэг	1,965,000.00	1,746,682.00	218,318.00	88.9
2107	Томилолт, зочдын зардал	106,589,000.00	87,131,000.00	19,458,000.00	81.7
210701	Гадаад албан томилолт	34,820,000.00	34,819,800.00	200.00	100.0
210702	Дотоод албан томилолт	71,769,000.00	52,311,200.00	19,457,800.00	72.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,797,675,000.00	576,224,465.83	1,221,450,534.17	32.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,656,000,000.00	2,197,259,812.69	458,740,187.31	82.7
220001	Барилга байгууламж	2,656,000,000.00	2,197,259,812.69	458,740,187.31	82.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,591,255,000.00	3,154,582,042.35	1,436,672,957.65	68.7
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,591,255,000.00	3,154,582,042.35	1,436,672,957.65	68.7
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	4,591,255,000.00	3,154,582,042.35	1,436,672,957.65	68.7
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		22,262,735.51		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		193,136,398.31		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		478,594,215.65		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	0	0	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төслийн үйл ажиллагаа

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл нь Архангай аймгийн Чулуут сум, Сүхбаатар аймгийн Наран суманд эмнэлгийн барилгын дулаан хангамжийн системийн мэдлэг, сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийг суурилуулах, засвар үйлчилгээ хийх чадавхыг сайжруулах, эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдлэг, орон сууцны эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэх дээшлүүлэх зорилготой Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Эрчим хүчний яамны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байна.

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл нь алслагдсан бүс нутгийн халаалтын хэрэгцээг байгаль орчинд ээлтэй, тогтвортой эх үүсвэрээр хангах зорилготой, сэргээгдэх эрчим хүчинд суурилсан халаалтын системийг туршиж, түүний үр ашиг, боломжийг бодит нөхцөлд үнэлэн, цаашид өргөжүүлэн нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр алслагдсан бүс нутгийн эрчим хүчний хүртээмж сайжирч, халаалтын зардал буурах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багасах, нүүрстөрөгчийн ялгарал буурах зэрэг олон талын эерэг үр дүн бий болно гэж үзэж байна. Мөн уг туршилтын үр дүнд үндэслэн сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийг бусад бүс нутагт нэвтрүүлэх боломж бүрдэх юм.

Төслийг Азийн хөгжлийн банк (АХБ), Цэвэр технологийн сан болон Номхон далайн бүс нутгийг дэмжих Японы сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Нийт санхүүжилтийн хэмжээ 2.1 сая ам.доллар бөгөөд үүнээс АХБ-аас 2.0 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газраас 0.1 сая ам.долларын татварын хөнгөлөлтөөр тус тус санхүүжүүлэхээр байна. Төслийн хэрэгжих хугацаа нь 2023 оноос 2027 онд хэрэгжинэ.

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 30 дугаар тушаалаар тус төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн хүрээнд хийх ажлын явц болон шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тухай бүр авч хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог байгуулсан байна.

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл нь Эрчим хүчний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль дүрэм, журмыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам" зэрэг болно.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 21 дүгээр бүлэг Гадаад зээл, тусламжийн бүртгэл, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр

сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,697,536.7 мянган төгрөгөөр буюу бараг 13.0 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	193,136.4	478,594.2	285,457.8
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	2,412,078.9	2,412,078.9
Нийт хөрөнгө	193,136.4	2,890,673.1	2,697,536.7
Хуримтлагдсан үр дүн	193,136.4	2,890,673.1	2,697,536.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	193,136.4	2,890,673.1	2,697,536.7

Дээрх хүснэгтээс харахад, бусад эргэлтийн бус хөрөнгийн данс 2,412,078.9 мянган төгрөгөөр нэмэгдэж өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Энэ нь Эрчим хүчний яам, төсөл болон Жи Пауэр ХХК, Повертүүл ХХК болон Электро Инженеринг ХХК-ийн түншлэлийн хооронд байгуулсан барилга угсралтын ажлын гэрээний дагуу Архангай аймгийн Чулуут сумын, Сүхбаатар аймгийн Наран сумын эрүүл мэндийн төвүүдийн барилгын дулаан алдагдлыг бууруулж, сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийг суурилуулах ажилд нийт 2,197,259.8 мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн, мөн тооцсон НӨАТ-ын чөлөөлөлтийн 214,819.1 мянган төгрөгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл тусламжийн 4,591,255.0 мянган төгрөгөөр бүрдүүлж, урсгал зардалд 1,935,255.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 2,656,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг гадаад буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр 3,154,582.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалтын зардалд 2,197,259.8 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 576,224.5 мянган төгрөг, төслийн нэгжийн зардалд 117,902.7 мянган төгрөг зарцуулж 63.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
80105	Хөрөнгө оруулалтын зардал	2,656,000.0	2,197,259.8	458,740.2	82.7
80105	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний зардал	1,797,675.0	576,224.5	1,221,450.5	32.1
80105	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал	137,580.0	117,902.7	35,552.3	85.7
ДҮН		4,591,255.0	2,891,387.0	1,699,868.0	63.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжих хувь	Зарцуулах төсөв	Зарцуулсан
70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл						
80105 Гадаадын тусламжаар гүйцэтгэх ажил						
1	Архангай аймгийн Чулуут сумын, Сүхбаатар аймгийн Наран сумын эрүүл мэндийн төвийн барилгыг дулааны алдагдалгүй болгон засвар хийж, сэргээгдэх эрчим хүчний халаалтын систем суурилуулан ашиглалтад хүлээлгэн өгөх	2025-2027	Архангай аймгийн Чулуут сумын эрүүл мэндийн төвийн барилгын дулааны алдагдалгүй болгон засвар хийж, сэргээгдэх эрчим хүчний халаалтын систем суурилуулж халаалтын 2 улирлын туршид найдвартай, тасралтгүй ажиллуулна.	97.0	2,656,000.0	1,324,628.0
		2025-2027	Сүхбаатар аймгийн Наран сумын эрүүл мэндийн төвийн барилгыг дулааны алдагдалгүй болгон засвар хийж, сэргээгдэх эрчим хүчний халаалтын систем суурилуулж халаалтын 2 улирлын туршид найдвартай, тасралтгүй ажиллуулна.	97.0		872,631.8
2	Иргэний нийгмийн байгууллага	2025-2026	Эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний халаалтын систем, ашиглалт арчилгааны талаар аймаг, сумын 50 албан тушаалтан, 60 ажилчин (25% эмэгтэйчүүд байх), 120 мэргэжилтэнг хамруулсан сургалтуудыг зохион байгуулах, ашиглалт үйлчилгээний гарын авлагаар хангана.	50.0	1,781,800.0	130,824.4
3	Төслийн зөвлөх	2024-2025	Эрчим хүчний хэмнэлтийн олон улсын зөвлөх	100.0		68,194.0
		2024-2025	Цэвэр халаалтын олон улсын зөвлөх	100.0		65,012.6
		2024-2025	Эрчим хүчний хэмнэлтийн дотоодын зөвлөх	92.0	63,098.1	

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

		2024-2025	Цэвэр халаалтын дотоодын зөвлөх	92.0		114,852.2
		2024-2025	Төслийн менежер дотоодын зөвлөх	92.0		118,612.0
4	Төслийн удирдлага	2023-2027	ТХН-ийн үйл ажиллагаа	87.0	153,455.0	133,533.8
Нийт дүн					4,591,255.0	2,891,387.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Номин, аудиторын туслах С.Булганчимэг, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр төслөөс ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 739,153.6 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 7,391.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн албан хэрэгцээнд албан тушаалтан нь суудлын автомашин ашиглаагүй батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 464,760.2 мянган төгрөгийн 38 мэдээлэл байршуулахаас зарлагын 61,062.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр тухай бүр мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар гадаадын 2 зөвлөхийн гэрээнд оршин суугч бус этгээдийн НӨАТ-ыг суутгах талаар тусгаагүй зөрчилд 1 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	1		1		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх зорилгоор инженер техникийн ажилтан, албан хаагчид орон нутагт албан томилолтоор ажиллахдаа гаднын байгууллагатай гэрээний дагуу тайлант онд автомашины түрээсийн төлбөрт 15,520.0 мянган төгрөг, жолоочийн томилолтын зардалд 7,820.0 мянган төгрөг олгосон байна. Үүнийг дараагийн тайлант онд дахин хянах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,720.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл гаргаагүй, тодруулга тайлангийн нэмэлт тайлбар бүрэн хийгдээгүй нь "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврын 8.2-т "Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулна", 8.5.3-т "Санхүүгийн тайлан болон мөрийн зүйлс нэг бүрийг толилуулсан дэс дарааллын дагуу санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан зүйлсийн талаарх дэмжих мэдээлэл болон бусад тодруулга" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Албан томилолтын урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоо дансаар дамжуулалгүй 19,720.0 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан нь Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 9.6-д "Урьдчилж төлсөн тооцоог дараах байдлаар бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг хэмжээний зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл гаргаагүй, тодруулга тайлангийн нэмэлт тайлбар бүрэн хийгээгүй,	1	19,720.0	1	19,720.0			1					
Албан томилолтын урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоо дансаар дамжуулалгүй 19,720.0 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан байна.	1	19,720.0	2	19,720.0			2	19,720.0				
Дүн	1	19,720.0	2	19,720.0			2	19,720.0				

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 61,062.2 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	61,062.2					1	61,062.2
Дүн	1	61,062.2					1	61,062.2